



ДУЛААН ТУСГААРЛАХ МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ
“МОНГОЛ БАЗАЛТ” ХК

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо,
Үйлдвэрийн тойруу-132, Утас: 7511-4444, 7017-0208

И-мэйл: monbasalt@rockwool.mn

2020.03.30 № 20/67
танай _____ № _____ д

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ-Д

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
цахим хэлбэрээр зохион байгуулах тухай

Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02-р сарын 14-ний өдрийн 4 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 04-р сарын 03-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж зарлан мэдээлээд байгаа билээ.

Гэвч энэ цаг үед дэлхийн хэмжээнд “COVID-19” коронавируст халдвар дэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар 2020 оны 62 дугаар тогтоолыг баталж шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд онцгой нөхцөл байдал үүссэн тул хуульд заасан хугацаанд ээлжит хурлаа Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн уриалга чиглэлийн дагуу нөхцөл байдалд нийцүүлэн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулахаар бэлтгэж, Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангуулахаар ажиллаж байна.

Хавсралтаар:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох заавар

Хүндэтгэсэн:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



А. ЭНХГЭРЭЛ



BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн нэр: “Монгол Базальт” ХК

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр, цаг: **2020** оны **04**-р сарын **03**-ны өдөр **15:00** цагт

Хурал хуралдах хэлбэр: “Монгол Базальт - Хувьцаа эзэмшигчдийн хурал 2020” Facebook группээр live хийж **цахим хэлбэрээр**

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хийх өдөр: **2020** оны **03**-р сарын **30**-аас **04**-р сарын **02**-н **Гаули ҮЦК** дээр өөрийн биеэр эсвэл итгэмжлэлтэй очиж бүртгүүлэн утасны дугаараараа бүртгэлийн код авна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоох,
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох,
4. ОХУ-ын Ангарск мужид салбар үйлдвэр байгуулах тухай хэлэлцэж батлах

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Хувьцаа эзэмшигчид нь 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 11:00 – 16:00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэрын 7 давхарт ирж танилцаж болно.

Нэмэлт мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын болон хуралд цахим хэлбэрээр хэрхэн оролцож санал өгөх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг компанийн цахим хуудас www.basaltwool.mn, Facebook “Монгол Базальт - Хувьцаа эзэмшигчдийн хурал - 2020” группт хандах эсвэл компанийн 7511-4444 утсаар холбогдож авах боломжтой.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Facebook хуудас: [www.facebook.com/Монгол Базальт - Хувьцаа эзэмшигчдийн хурал 2020](https://www.facebook.com/Монгол-Базальт-Хувьцаа-эзэмшигчдийн-хурал-2020)

утас: 7511-4444

вэб сайт: www.basaltwool.mn

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?



Хувьцаа



Цахим үнэмлэхтэйгээ

“ГАҮЛИ” ҮЦК

Хаяг: УБ хот, СБД, 8-р хороо,
Оюутны гудамж, “Сонор плаза” төв,
602 тоот /Хуучнаар багшийн дээд/
Утас: 7015-3300

1



“ГАҮЛИ” ҮЦК компани

Тайлбар:

2020.03.30 - 2020.04.02-ны өдрийн
09.00 - 17.00 цагийн хооронд
өөрийн биеэр эсвэл итгэмжлэлтэй
очиж ХУРЛЫН МЭДЭГДЭЛ
БӨГЛӨНӨ.

/ Ингэснээр ТА хуралд цахимаар оролцож,
санал өгөх боломжтой болно. /

2



“Монгол Базальт - Хувьцаа
эзэмшигчдийн хурал - 2020”
нэртэй Facebook групп-т нэгдэнэ

3

“Монгол Базальт” ХК-ийн Хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурал
2020.04.03-ний өдрийн 15.00 цагт



-аар явуулна. /Хурал
дэгийн дагуу явагдана/

4



Гар утас, компьютер ашиглан ГЭР,
АЖИЛ болон өөрийн хаа байгаа
газраас хувьцаа эзэмшигчдийн
хурлын хэлэлцэж байгаа
асуудлаар саналаа өгнө.

/ Санал өгөх зааврыг бүртгүүлсэн гар
утасанд мессежээр илгээнэ /